

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА,  
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН  
ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 30, 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 25, 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслүүдтэй холбогдуулан Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг дахин хэлэлцэх шаардлагатай гэсэн горимын санал гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд буцаасан.

Төсвийн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулж, өмнөх хуралдаанаар хэлэлцсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжин, нэмж боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1.Эм, эмнэлгийн хэрэгсэл “чанар ба үнийн хосолмол” үнэлгээ хийх шалгуурыг хуулийн төсөлд шинээр нэмж, чанар ба үнийн хосолмолд хамаарах оноог тендер шалгаруулалтын баримт бичигт тендер зарлахаас өмнө тусгах;

2.Хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгч, олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах зохицуулалтыг өөрчлөн найруулах;

3.Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч сонгон оролцуулахтай холбогдох худалдан авах ажиллагааг энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамааруулахгүй байх зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах;

4.Шүүх шинжилгээний хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай уялдуулан шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал бол шууд гэрээ байгуулна гэсэн саналууд гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хуулийн төсөлд тусгасан “төрийн өмчийн музей болон галерейн сан хөмрөгийг баяжуулах зорилгоор түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг нэг өмчлөгчөөс буюу нэг эх үүсвэрээс худалдан авах” аргад орон нутгийг хамруулах нь зүйтэй гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН